

Төслийн хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн 2008 оны тайлан

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Төслийн Удирдах хорооны хурлын бэлтгэлийг хангуулан 3 удаа хуралдуулж дараах асуудлуудыг хэлэлцүүлж, зохих шийдвэр гаргуулсан. Үүнд:

- Тогтвортой амьжиргаа-II төслийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, цалинг батлуулах
- Төслийн заавруудыг батлуулах
- Тогтвортой амьжиргаа-II төслийн ажлын хэсгүүд болон зөвлөлийг байгуулах
- Төслийн ажилтнуудын нээлттэй сонгон шалгаруулалт явуулах тухай
- Тогтвортой амьжиргаа-II төслийн газрын дүрэм

Сум, дүүргийн төслийн зохицуулагчийн ажил үүргийн хуваарийг боловсруулж Дэлхийн банкнаас зөвшөөрөл авсны үндсэн дээр орон нутгийн зохицуулагчдын сонгон шалгаруулалтыг амжилттай явуулсан. Ингэснээр аймаг, нийслэлийн 22, сум, дүүргийн 338 зохицуулагчтай гэрээ байгуулж ажлыг нь эхлүүлсэн.

Удирдах хорооны шийдвэрийн дагуу ТАТГ-ын захирлын тушаалаар БМААЭУ, ОНС-ын ажлын хэсгүүд, МБ-ны Ерөнхийлөгчийн тушаалаар БСХЗ байгуулагдсан. Аймаг, нийслэл, дүүргүүдэд төслийн зөвлөл, ажлын хэсгүүд байгуулагдсан.

Төслийн бүх заавруудыг 5-р сард монгол, англи хэлээр, мөн Баян-Өлгий аймгийн үндэсний цөөнхөд зориулж казак хэл дээр хэвлүүлж аймаг, нийслэл, сум, дүүргүүдэд тараасан.

Тогтвортой амьжиргаа-II төслийн албан ёсны нээлтийн ажиллагааг 5-р сарын 16-нд Улаанбаатар хотод зохион байгуулсан.

Хоёр. Боловсруулсан ба хянаж шийдвэрлэсэн асуудлуудын талаар

А. БМААЭУ бүрэлдэхүүн хэсэг

БМААЭУ бүрэлдэхүүн хэсэгт дараах чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын удирдамжийг боловсруулж Дэлхийн банкнаас зөвшөөрөл авсан. Үүнд:

- МАА-н эрсдэлийг урьдчилан мэдээлэх тогтолцоо бий болгох
- Төсөлд шинээр хамрагдах аймгуудад бэлчээрийн зураглал, төлөвлөгөө боловсруулах
- Төсөлд өмнө нь хамрагдсан аймгуудад давтан сургалт явуулах
- Эрсдэлийг бууруулах, хариу төлөвлөлт хийх

МААЭУМТ-г бий болгох ажлыг гүйцэтгэх “Мэрсси Корпс” байгууллагыг нэг эх үүсвэрийн (Single Source Selection) сонголтын аргаар гэрээлэн авч ажиллуулах талаарх үндэслэл, дүгнэлтийг гарган өгч ДБ-наас зөвшөөрөл авсан.

Туршилтын 8 аймагт давтан сургалт явуулах ажлыг гүйцэтгэх “Бодлого судлалын төв” байгууллагыг нэг эх үүсвэрийн (Single Source Selection) сонголтын аргаар гэрээлэн ажиллуулах талаарх үндэслэл, дүгнэлтийг гарган өгч ДБ-наас зөвшөөрөл авсан.

Баян-Өлгий, Төв аймгаас ирүүлсэн БМААЭУ-ын нийт 17 дэд-төслийг ТАТГ хүлээн авч хянан, хэрэгжүүлэх зөвшөөрлийг өгч санхүүжүүлсэн байна. /Хавсралт 1-ийг үзнэ үү/

Б. Олон нийтийн санаачилга бүрэлдэхүүн хэсэг

“ОНСС-ийн төслүүдийг хэрэгжүүлэхэд иргэд, олон нийтийг идэвхжүүлэх” үйл ажиллагаанд шаардагдах зөвлөх үйлчилгээний ажлын удирдамж болон ажиллах ТББ-ыг сонгох тайлбар тодорхойлолтыг боловсруулж эцэслэн Дэлхийн банкнаас зөвшөөрөл авсан. Бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд үйл ажиллагааны ажилтан шинээр авч ажиллуулж байна.


ОНСС-ийн хөрөнгийн хуваарийн томъёоллыг эцэслэн боловсруулж нийслэлийн дүүргүүд болон туршилтын 8 аймгуудын хөрөнгийн хуваарийг батлуулж хүргүүлсэн. 2008 онд нийт 2.32 тэрбум төгрөгийн 386 төслийг өмнө туршилтаар сонгогдсон 8 аймаг, Орхон, нийслэлийн 9 дүүргээс хүлээн авч хянаж үзсэний үндсэн дээр хэрэгжүүлсэн. /Хүснэгт 1, аймаг/нийслэлийн дэлгэрэнгүй төслийн жагсаалтыг Хавсралт 2А-д үзүүлэв/ Үүнд орон нутаг болон иргэдээс төслийн нийт өртгийн 10 хувийг санхүүжүүлсэн болно.

Хүснэгт 1

№	Аймаг/нийслэлийн нэр	Төслийн тоо	Төслийн хөрөнгө
1	Баян-Өлгий	35	200,402,441
2	Баянхонгор	35	283,698,261
3	Дорнод	17	128,843,999
4	Дундговь	41	171,934,650
5	Өвөрхангай	54	271,999,599
6	Өмнөговь	25	162,391,452
7	Төв	50	364,168,873
8	Увс	25	184,341,377
9	Орхон	11	47,370,700
10	Улаанбаатар	93	505,031,504
	Нийт	386	2,320,182,856

Эдгээр хэрэгжүүлсэн төслүүдийг санхүүжилтээр нь салбарын чиглэлээр нь схем 1-т үзүүлээ.

Схем 1



Иргэдийг идэвхжүүлэх үйл ажиллагааг орон нутагт гүйцэтгүүлэхээр "Нийгмийн хөгжлийн төв" төрийн бус байгууллагыг зөвлөхөөр сонгон шалгаруулж орон нутгийн иргэдийг идэвхжүүлэгчдийг сонгох ажлын хүрээнд аймгуудад сургалтууд зохион байгуулж, үйл ажиллагаагаа эхлээд байна.

Монголын хөгжлийн захын 114,45 сая төгрөгийн 12 дэд-төслийн төсөл хэрэгжүүлэх гэрээг эцэслэн байгуулж, тэдгээрийн эхний санхүүжилтийг хийж, төслүүдийн үйл ажиллагааг эхлүүлэн хэрэгжүүлж байгаа ба одоогоор 4 төслийг бүрэн хэрэгжүүлж дууссан. /Хавсралт 2Б-г үзнэ үү/

В. Оролцооны хяналт, шинжилгээ ба үнэлгээ

2008 онд Тогтвортой амьжиргаа-II төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээний бэлтгэл ажил үндсэндээ хангагдаад байна. Үүнд: 21 аймагт 329 сумын зохицуулагчид сургалтад хамрагдсанаар ХШҮ-ний талаарх суурь ойлголт, оролцоог хангах механизмуудын талаар ойлголттой боллоо. Туршилтын аймгуудын хувьд төслийн сумын зохицуулагчид мэдлэгээ улам бататгаж, сайн туршлагаа солилцсон бол туршилтын бус аймгуудын хувьд хяналт-шинжилгээний ажлыг хэрхэн юунаас эхлэх, ямар шалгуур үзүүлэлтээр төслийн үр дүнг тооцох талаар тодорхой ойлголттой боллоо.

Төслийн ОХШҮ-г үр дүнтэй, цаг тухайд нь чанартай явуулах боломжийг хангахын тулд ХШҮ-ний заавар 4300 ширхэг, олон нийтийн хянагч, үнэлээч нарыг татан оролцуулах, иргэдийг төслийн ХШҮ-д оролцохыг уриалсан сурталчилгааны эвхмэл хуудас 50000 ширхэг, ХШҮ-нд ашиглах 557220 ширхэг маягт, 6620 ширхэг хянагч, үнэлээч нарын энгэрийн тэмдэг, 800 ширхэг сургалтын хөтөлбөр, 6680 ширхэг бие даан судлах гарын авлагыг хэвлүүлэн бүх сумдад хүргүүллээ. Ингэснээр сумын зохицуулагчид шаардлагатай үедээ иргэдэд сургалт явуулах ба иргэдийг төслийн хяналт-шинжилгээний ажилд зохих бэлтгэлтэй оролцуулах боломжтой боллоо.

Тогтвортой амьжиргаа-II төслийн ХШҮ-ний тогтолцоо нь нэгдмэл, УМС-д суурилсан байх ба өмнөх үе шатанд ТАТГ-ын ХШҮ-нд хамрагддаггүй байсан Бичил санхүүгийн хөгжил бүрэлдэхүүн хэсгийн БСХС-ийн дэд зээлдэгчдийн ХШҮ-г ТАТГ-аас хийж эхэллээ. Одоогоор 2000 гаруй идэвхтэй зээлийн ХШҮ хийгдэж байна. Энэ нь УМС-ээр тайлагнах үйл явцыг сайжруулахад чиглэгдэж байна. УМС-ийн ХШҮ-ний үзүүлэлтүүдийг оруулах, тайлангийн маягыг боловсруулах ажил хийгдэж байна.

2008 онд төлөвлөгдсөн Тогтвортой амьжиргаа-II төслийн суурь судалгааг амжилттай хийлгэж дуусган, төгсгөлийн тайланг хүлээн авч Дэлхийн банкинд явуулсан болно.

Г. Худалдан авах ажиллагаа

ТАТГ-ын түвшинд нийт 400,390,211 төгрөгийн өртөг бүхий бараа, ажлыг хийж гүйцэтгэх 15 гүйцэтгэгч нийлүүлэгчийг, нийт 808,139.78 ам.долларын өртөг бүхий зөвлөх үйлчилгээг үзүүлэх 3 гүйцэтгэгчийг тус тус сонгон шалгаруулж гэрээ байгуулан ажлын гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллав. Олон нийтийн санаачлага бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд “Олон нийтийг идэвхижүүлэх аргачлалыг боловсруулж хэрэгжүүлэх” мөн Бэлчээрийн Мал Аж ахуйн Эрсдлийн Удирдлага /БМААЭУ/ бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд “Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах, өөрчлөн сайжруулах, үнэлэх чиглэлээр туршилтын 8 аймагт давтан сургалт хийх” зөвлөх үйлчилгээг хийж гүйцэтгэх зөвлөх компанийг нэг эх үүсвэрийн аргаар тус тус сонгон шалгаруулж гэрээлэв. Мал аж ахуйн эрсдлийг урьдчилан мэдээлэх тогтолцоог бий болгох чиглэлээр нэг эх үүсвэрийн аргаар зөвлөх үйлчилгээний компанийг сонгон шалгаруулж, гэрээлэх ажил санхүүгийн хэлцэл хийх, Дэлхийн банкнаас гэрээ байгуулах зөвшөөрөл авах түвшинд явагдаж байна. Мөн БМААЭУ бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд “Бэлчээрийн зураглал, бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулах болон загвар сум бий болгоход техникийн тусламж үзүүлэх” мөн “Хяналт шинжилгээ үнэлгээний чиглэлээр олон нийтийн чадавхийг бэхжүүлэх” зөвлөх үйлчилгээг хийж гүйцэтгэх зөвлөх компанийг сонгон шалгаруулах ажил сонгон шалгаруулалтанд оролцох сонирхолоо илэрхийлсэн компаниудад үнэлгээ хийж, хураангуй жагсаалт гаргах түвшинд хийгдэж байна.

БМААЭУ, ОНС бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд орон нутагт зохион байгуулсан нийт 2,304,056,851 төгрөгийн өртөг бүхий нийт 257 тендерийн материалыг хянаж гэрээ

байгуулах эрх олгосон болно. Тендер зохион байгуулснаар батлагдсан төслүүдийн анхны төсөвт өртөгтэй харьцуулахад нийт 83,168,127 төгрөгийн хэмнэлт гаргав.

Аймаг, сум, УБ хот, дүүргийн түвшний худалдан авах үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласнаар худалдан авах үйл ажиллагааны зохион байгуулалтын чадавхи аймаг, сумын түшинд ерөнхийдөө бэхжин сайжирсан, төсвийн хөрөнгийн үр ашигтай зарцуулалтын байдал дээшилсэн, төвлөрлийг сааруулж аймаг, сумын хэмжээнд тендер бие даан зохион байгуулах эрх мэдэл олгогдсон, аймаг сумын хэмжээнд хувийн хэвшлийн байгууллагуудын тендерт оролцох чадамж, идэвхи дээшилсэн болно.

Гурав. Сургалт, сурталчилгааны талаар

Сургалт

Монгол Улс, Олон улсын хөгжлийн ассоциацийн хооронд байгуулсан “Санхүүжилтийн гэрээ”-ний “Хүчин төгөлдөр болох, дуусгавар болох” гэсэн Ү зүйлийн 5.01. d/ заалтын “ТАХА болон ТАХН тус бүрийн ажилтнууд санхүүгийн удирдлага, хөрөнгийн зарцуулалт, худалдан авах ажиллагаа, түүний дотор Төсөл хэрэгжүүлэх зааврын талаархи Ассоциацийн шаардлагын хэмжээнд зохион байгуулсан сургалтын дамжааг дүүргэсэн байх” гэсэн шаардлагыг хангах үүднээс төслийг эхлүүлэх, төслийн чиг баримжаа олгох дараах сургалтуудыг зохион байгуулав. Үүнд:

1. БМААЭУ, ОНС бүрэлдэхүүн хэсгийн ажлын хэсгийн гишүүдэд зориулсан ТА-II төслийг танилцуулах тус бүр 1 өдрийн сургалт/семинарыг 2008 оны 04 дүгээр сарын 7, 8-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулав. Сургалтад нийт 27 хүн хамрагдсан бөгөөд тэдэнд төслийн ерөнхий заавар, бүрэлдэхүүн хэсгүүдийн талаар дэлгэрэнгүй танилцуулж, нээлттэй ярилцлага зохион байгуулсан.
2. ТАТГ, БСУН-ийн ажилтнуудад зориулсан төслийн заавар, журмуудыг танилцуулах 3 өдрийн сургалтыг 4 дүгээр сарын 14-16-ны өдрүүдэд УБ хотод зохион байгуулав. Тус сургалтад нийт 22 ажилтан хамрагдсан ба төслийн заавар, журмуудыг дэлгэрэнгүй танилцуулсан.
3. ТА-II төслийг эхлүүлэх, заавар, журмуудыг танилцуулах тус бүр 5 өдрийн сургалтыг аймаг, нийслэл, дүүргийн төслийн зохицуулагчдад 2008 оны 04 дүгээр сарын 21-25-ны өдрүүдэд, нягтлан бодогчдод 04 дүгээр сарын 28-наас 5 дугаар сарын 02-ний өдрүүдэд тус тус УБ хотод зохион байгуулав. Эдгээр сургалтад нийт аймаг, нийслэл, дүүргийн 53 зохицуулагч, нябо хамрагдсан. Сургалтаар оролцогчдод төслийн зорилго, зорилт, бүтэц зохион байгуулалт, бүрэлдэхүүн хэсгүүд, хэрэгжүүлэх үйл ажиллагаануд, худалдан авах, ажиллагаа, хяналт, шинжилгээ ба үнэлгээ, санхүүгийн дүрэм журмыг дэлгэрэнгүй танилцуулж, маягтууд дээр ажиллуулж, дадлага ажил хийлгэв. Сургалтын дараа оролцогчдоос өгсөн үнэлгээнээс үзвэл ихэнх оролцогчид

төслийн талаар бүрэн ойлголт авсан, заавар журмууд хэрэгжүүлэхэд хялбар болсон гэж дүгнэсэн байна. Харин зарим оролцогч БМААЭУ, БСҮ бүрэлдэхүүн хэсгийг дахин сайн судлах шаардлагатай гэж үзсэн байв. Ихэнх оролцогч үнийн өсөлттэй харьцуулахад цалин хэт бага байгаа тул нэмэгдүүлэх, нийгмийн асуудалд анхаарах, хэсэг хугацааны дараа давтан сургалтад хамрагдах шаардлагатай талаар санал тавьсан байв.

4. ТА-II төслийн үйл ажиллагаанд удирдлагын мэдээллийн системийн шинэ программ хэрэглэж эхлэхтэй холбогдуулан УМС-ийн программ танилцуулах, дадлага олгох сургалтыг 2008 оны 04 дүгээр сарын 28-наас 5 дугаар сарын 9-ний өдрүүдэд аймаг нийслэл, дүүргийн төслийн зохицуулагчдад, 05 дугаар сарын 04-нөөс 09-ний нягтлан бодогч нарт зориулан тус тус УБ хотод зохион байгуулав. УМС-ийн сургалтад нийт 53 хүн хамрагдсан. Уг сургалтаар УМС-ийн бүтэц, тогтолцоо, өгөгдлийн сан, файл дамжуулах, мэдээлэл бүртгэх, шалгах талаар дэлгэрэнгүй танилцуулж, дадлагын ажил хийв. Үнэлгээнээс үзвэл оролцогчид УМС-ийн шинэчилсэн программын талаар бүрэн ойлголт авсан, ашиглахад хялбар болсон боловч давтан сургалт, дадлага зайлшгүй шаардлагатай гэж үзсэн байна.
5. Аймаг, нийслэл, дүүргийн ТАТЗ/ЗДЗ, ажлын хэсгийн гишүүд, сумдын төслийн зохицуулагч нарт зориулан ТА-II төслийг эхлүүлэх, төслийн чиг баримжаа олгох, заавар, журмуудыг танилцуулах 4-5 өдрийн сургалтыг 2008 оны 5–8 дугаар саруудад нийт 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн түвшинд зохион байгуулав. ТАТГ-ын холбогдох ажилтнууд батлагдсан хуваарь, хөтөлбөрийн дагуу аймаг бүрт очиж хичээл заасан болно. Сургалтаар оролцогчдод төслийн зорилго, зорилт, бүтэц зохион байгуулалт, бүрэлдэхүүн хэсгүүд, хэрэгжүүлэх үйл ажиллагаануд, худалдан авах ажиллагаа, хяналт, шинжилгээ ба үнэлгээ, санхүүгийн дүрэм журмыг дэлгэрэнгүй танилцуулж, маягтууд дээр ажиллуулж, дадлага ажил хийлгэсэн ба хичээл бүрийн дараа оролцогчдоос төслийн шалгалт авч мэдлэгийг нь баталгаажуулж байв. Эдгээр сургалтад нийт 1010 хүн хамрагдсан ба сургалтын үед оролцогчдыг гарын авлага, илтгэл, хэвлэгдсэн заавар, журмуудаар хангасан. Аймгийн түвшний сургалт бүрийн дараа оролцогчдоос сургалтын үнэлгээ авсан бөгөөд ихэнх оролцогчид төслийн заавар, журмын талаар талаар дэлгэрэнгүй ойлголт авсан ба цаашид төслийг орон нутагтаа эхлүүлэхэд бэлэн боллоо гэж үзсэн байна.
6. 21 аймгийн нийт сумдын ТАТЗ/ЗДЗ, БМААЭУ-ын Техникийн хорооны гишүүд, багийн Засаг дарга нарт ТА-II төслийн заавар, журмуудыг танилцуулах сургалтыг зохион байгуулж эхэлсэн ба аймгийн төслийн зохицуулагч, ня/бо нар сум бүр дээр очиж 2 өдрийн сургалт зохион байгуулсан. Сургалтанд нийт 21 аймгийн 330 сумын 5140 хүн хамрагдсан байна.
7. Аймаг, нийслэл, дүүргийн Тогтвортой амьжиргаа-II төслийн зохицуулагчдад зориулсан төслийн хэрэгжилтийн талаар ярилцах ажил төрлийн семинарыг энэ оны 12 дугаар сарын 15-16-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулав. Семинарт нийт 31 хүн оролцсон бөгөөд зохицуулагчид төсөл

хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаанд хийгдэж буй ажлууд, тулгарч буй бэрхшээл, ажил сайжруулах талаар ТАТГ-ын ажилтнуудтай дэлгэрэнгүй ярилцаж цаашид хийх ажлын зорилгоо тодорхойлов.

8. 2008 онд аймаг, орон нутагт төслийг хэрэгжүүлсэн явц байдал, тулгарч буй бэрхшээл, цаашид тавих зорилтын талаар ярилцах ажил төрлийн семинарыг 2008 оны 12 дугаар сард багтаан сумын төслийн зохицуулагч нарт зориулан аймгийн түвшинд зохион байгуулав. Уг семинарт нийт 384 хүн оролцож 2009 онд хийх ажлын чиглэлээ тодорхойлж, төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар ярилцсан болно.
9. 2008 оны орон нутгийн сонгуулийн дараа шинээр томилогдсон аймаг, сумдын Засаг дарга, ажлын хэсгийн гишүүд болон сумдын зохицуулагч нарт ТА-II төслийн заавар, журмуудыг танилцуулах сэргээх сургалтыг туршилтын нийт аймаг, нийслэл, дүүргийн түвшинд зохион байгуулж байна.

ТАТГ-ын ажилтнуудын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх зорилгоор нийт 6 ажилтаныг гадаад оронд төслийн удирдлага, төслийн цикл, компьютерийн програм хангамж, санхүү, нягтлан бодох, бүртгэлийн чиглэлээр сургалтанд хамруулав.

Сурталчилгаа

Чингэлтэй дүүргийн урд байрлах төслийн сурталчилгааны самбарыг засварлуулж, мэдээлэлжүүлсэн. Улаанбаатар телевизээр нийт 5 удаагийн ярилцлага, нэвтрүүлгийг бэлтгүүлж нэвтрүүлсэн. ТАТГ-ын захирал А.Хашцэцэг, ТХЗХ-ийн дарга Г.Пагма, ОНС бүрэлдэхүүн хэсгийн зохицуулагч М.Энхбат нарын ярилцлагыг бэлтгэж, мөн БМААЭУ, ОНС бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр сурталчилгааны материалыг Өдрийн сонин, Зууны Шуудан сонингуудад нийт 10 дугаарт хэвлүүллээ.

Төслийн талаарх мэдээлэл, сурталчилгааг иргэдэд тогтмол, шуурхай хүргэж байх зорилгоор Монголын Үндэсний Олон Нийтийн телевиз, радио, Улаанбаатар телевиз, Өдрийн сонин, Зууны шуудан сонин, FM 107,5 радиотой хамтран ажиллах гэрээнүүдийг байгуулж ажилласан. Нийслэлийн 9 дүүргийн зохицуулагчид оролцсон богино долгионы радиогийн 10 цуврал ярилцлага нэвтрүүлгийг бэлтгэж явуулсан. Төслийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн үйл ажиллагааг харуулсан, олон нийтийг идэвхжүүлэхэд зориулсан зурагт хуудасны эхийг гаргаж, хэвлэлтэд бэлтгэж нийт 44000 ширхэг хэвлүүлж 21 аймаг нийслэлийн 9 дүүрэгт хуваарилав .

Тогтвортой амьжиргаа төслийн хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг харуулсан баримтат кино, телевизийн сурталчилгааны шторкуудыг МҮОНТ-ийн “Tick entertainment” студитэй гэрээ байгуулан хийлгэж, баримтат киног Улаанбаатар телевизээр 2 удаа цацуулж мөн 30 ширхэг олшруулан хэвлүүлж аймаг дүүргүүдийн зохицуулагч нарт өгсөн. Төслийн телевизийн сурталчилгааны шторкийг Улаанбаатар телевизээр нийт 4020 секунд мэдээлэлийн нэвтрүүлгийн

дундуур цацууллаа. Төслийн 2009 оны ханын болон ширээний хуанлиг хэвлэлтэнд бэлтгэж тус бүр 2500 ширхэг хэвлүүлж 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт хуваарилаж хүргүүлсэн. Монголын Үндэсний олон нийтийн радиотой хамтран ажиллах гэрээний дагуу ТХЗХ-ийн дарга Г.Пагма, БМААЭУ-ын зохицуулагч С.Батсайхан, ОНС бүрэлдэхүүн хэсгийн зохицуулагч М.Энхбат, Баянгол дүүрэг, Сэлэнгэ, Төв аймгуудын ТАТ-ын зохицуулагч нар оролцсон нийт 6 удаагийн радио ярилцлага нэвтрүүлгийг цацууллаа.

Дөрөв. Орон нутагт ажилласан талаар

Хэлтсийн дарга, бүрэлдэхүүн хэсгийн зохицуулагч болон холбогдох мэргэжилтнүүд 21 аймаг, нийслэлд сургалт зохион байгуулахад оролцох үедээ аймаг, сумдын зохицуулагч нарт ажил төрлийн талаар зөвлөгөө өгч ажилласан. Тайлант хугацаанд Булган, Төв, Дорноговь аймгуудад томилолтоор ажиллаж төслийн хэрэгжилтийн байдалтай танилцаж, заавар, зөвлөгөө өгсөн.

Төслийн хэрэгжилтийг зохицуулах хэлтэс
2009-02-09